



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 5/МД

Хэрлэн сум

С.Оюун-Эрдэнийг албан
тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Сумъяагийн Оюун-Эрдэнэ нь зургаан сараас дээш хугацааны сургалтаар бэлтгэгдэх болсон тул 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусгавар болгон албан тушаалаас бүр чөлөөлж, төрийн албанаас түр чөлөөлсүгэй.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ч.Баярцолмон Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Г.Тэмүүжин Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Баяртуяа Нярав

3.С.Оюун-Эрдэнийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Ч.Баярцолмон)-т, холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА